

ЗӨВЛӨХИЙН ТЕНДЕРИЙН УРИЛГА

1. Увс аймаг дахь Төрийн аудитын газраас гэрээгээр 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээнд урьж байна.

2. “Төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийж гүйцэтгэх ажил”-ыг 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс 03 дугаар сарын 15-ны хооронд бүрэн хийж дуусгах болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь дараах мэдээллийг ирүүлнэ үү. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабар хугацаатай нийцсэн эсэх (тендерийн явцад тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байгаа тохиолдолд тухайн байгууллагаас лавлагаа авсан байх);
- Аудитын компанийн захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ээс зохих зөвшөөрөлтэй байх;
- Аудитын хуулийн этгээд нь 2-оос доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх; /Шаардлагатай бол 4-өөс доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх/
- Аудитын компанийн захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаагүй талаар Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ийн тодорхойлолттой байх;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчөөгүй байх;
- Аудиторууд нь аудитын ажил хийж гүйцэтгэсэн 2-оос доошгүй жилийн туршлагатай байх (Хэрэв улсын салбарт аудит хийсэн туршлага шаардлагатай бол тендерийн баримт бичигт тусгайлан заана);
- Шаардлагатай бол санхүүгийн зохицуулах хороонд “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлсэн байх.
- Сангийн Яам болон бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн чанарын баталгаажуулалтын дүгнэлт (хэрэв шаардлагатай бол).

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Материалыг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл Увс аймаг дахь Төрийн аудитын газарт хүлээн авна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Утас:70453317, 70453721